

2021 ОНЫ 1 ДҮГЭЭР УЛИРЛЫН ӨРГӨДӨЛ ГОМДЛЫН
ШИЙДВЭРЛЭЛТИЙН ТАЙЛАН

2021 оны 03 дугаар сарын 25 өдөр

Улаанбаатар хот

Нийслэлийн Засаг даргын 2013 оны А/1086 дугаар захирамжаар батлагдсан “Нийслэлийн Нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлыг шийдвэрлэх журам”-ын 12.1.2-т заасны дагуу өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн талаар дараах ажлыг хийж хэрэгжүүлсэн болно.


Үүнд:

1. Нийслэлийн Засаг даргын 2013 оны А/1086 дугаар захирамжаар батлагдсан “Нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх журам”-ыг баримтлан өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийг эрчимжүүлэн нийслэлийн хэмжээнд ашиглаж байгаа дотоод удирдлагын egr.ulaanbaatar.mn нэгдсэн системийн өргөдөл гомдлын дэд системд иргэдээс гаргасан өргөдөл гомдлыг хүлээн авч бүртгэв. 2021 оны 1 дүгээр улирлын байдлаар нийт 29 өргөдлийг бүртгэж, 28 өргөдлийг хуулийн хугацаанд шийдвэрлэж, 1 өргөдөл шийдвэрлэх шатандаа байна.
2. Нийслэлийн Засаг даргын 2019 оны А/938 дугаар захирамжаар манай байгууллагын зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаарыг шинэчлэн баталсан бөгөөд 3 хэлтэстэй /Захиргаа, хүний нөөцийн хэлтэс, Санхүү төлөвлөлтийн хэлтэс, Тээвэр зохицуулалтын хэлтэс /, нийт 102 албан хаагчтай үүнээс захиргааны 9 албан хаагчийг “Өргөдөл, гомдлын нэгдсэн программ”-д бүртгэн нэвтрэх эрхтэйгээр өргөдөл гомдлыг шийдвэрлэж байна. Бусад албан хаагч нь асуудлыг шийдвэрлэх түвшний албан тушаалтан биш болно.

ӨРГӨДӨЛ ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТИЙГ
ӨМНӨХ ОНТОЙ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ


2021 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 03 дугаар сарын 25-ны өдрийг хүртэлх хугацаанд манай байгууллагад ирсэн нийт 29 өргөдөл, гомдлыг “Өргөдөл, гомдлын нэгдсэн программ”-д бүртгэсэн байна. 2021 оны 01 дүгээр сарын 01 өдрөөс 03 дугаар сарын 25-ны өдрийг хүртэлх өргөдлийг 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 03 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар өргөдөл гомдлыг харьцуулахад 2020 оныхоос 19 өргөдлөөр бага байна. Өнгөрөгч 2020 оны 1 дүгээр улирлын байдлаар 48 өргөдөл, гомдол хүлээн авч хууль зүйн үндэслэлтэй шийдвэрлэсэн байна. 2020-2021 оны өргөдөл гомдлын шийдвэрлэлтийг дараах графикаар харьцуулсан.

График-1



2021 оны 1 дүгээр улиралд ирүүлсэн өргөдөл, гомдол, санал хүсэлтийг /диаграмм-2/ Захиргаа хүний нөөцийн хэлтэс 13, Санхүү, төлөвлөлтийн хэлтэс 16, Тээвэр зохицуулалтын хэлтэст өргөдөл ирүүлээгүй бөгөөд байгууллагын хэмжээнд нийт 29 өргөдөл гомдлоос журмын дагуу хуулийн үндэслэлтэй 28 өргөдөл, гомдлыг шийдвэрлэж, шийдвэрлэх шатандаа байгаа 1 өргөдөл байна.

Диаграмм 2



/2021 оны 1-р улирал/

2021 оны 1 дүгээр улирлын байдлаар хандалтаараа тэргүүлж байгаа 3 асуудал нь байгууллагын албан хаагчдаас нийгмийн асуудал ахуй амьдралаа дээшлүүлэх зорилгоор цалингийн зээл, хэрэглээний болон лизингийн зээл авах хүсэлтүүд 11 /37.93%/ байна. Нийгмийн асуудал шийдвэрлүүлэхээр ирүүлсэн 7 /24,14%/ байна. Мөн буцалтгүй тусламж хүссэн өргөдөл 2 /6.90%/ байна.

Өргөдөл, гомдлын программд нийт 29 өргөдлийг бүртгэж, 29 өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн хариуг журмын дагуу 5 хоногт 25 (89,29%), 10 хоногт 2 (7,14%), 30 хоногт 1 (3,57%). Шийдвэрлэх шатандаа байгаа 1 өргөдөл байна. Хугацаа хэтэрч шийдвэрлэсэн өргөдөл гомдол байхгүй болно. Өргөдөл, гомдлын индексээр (PCI) 0,87 буюу "B" үнэлгээтэй байна.

Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн үзүүлэлтийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад:



Нийслэлийн Төр захиргааны авто бааз УТҮГ-ын өргөдөл гомдлын зөрчлийн тайланг өмнөх онтой харьцуулахад 10 нэгжээр буурсан, хугацаа хэтэрч шийдвэрлэсэн өргөдөл гомдол байхгүй байна.

Нийслэлийн Засаг даргын 2021 оны 01 дүгээр хуралдааны тэмдэглэлээр өгсөн үүрэг, даалгаврын биелэлтийг хангуулах ажлын хүрээнд байгууллагаас 2021 онд хэрэгжүүлэх тусгай төлөвлөгөө гарган, иргэдээс ирүүлсэн өргөдөл гомдол, санал хүсэлтийг шийдвэрлэхээр дараах ажлыг зохион байгуулан ажиллан, биелэлт үр дүнг тооцон ажиллалаа. Үүнд:

1. Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн мэдээг сар бүр гаргаж байгууллагын даргад танилцуулж, шийдвэрлэлтийн зөрчил гаргасан, хугацаа хэтрүүлсэн албан хаагчдад шаардлага тавьж, хяналтыг сайжруулан ажилласан. Өргөдөл гомдлын шийдвэрлэлтэд хугацаа хэтэрч

шийдвэрлэсэн өргөдөл гомдол байхгүй. Явцын тэмдэглэл хөтлөөгүй, өдөрт нь хүлээн аваагүй зөрчил нийт 3 зөрчил гаргасан бөгөөд холбогдох албан хаагчдад шийдвэрлэлтийн талаар чиглэл өгч, сануулах арга хэмжээ авч ажилласан байна.

ТАНИЛЦСАН:
НИЙСЛЭЛИЙН ТӨР ЗАХИРГААНЫ
АВТО БААЗ УТҮГ-ЫН ДАРГА



Ш.НАРАНБААТАР

ХЯНАСАН:
ЗАХИРГАА ХҮНИЙ НӨӨЦИЙН ХӨЛТСИЙН
ДАРГА, ХҮНИЙ НӨӨЦИЙН
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Н.БАТЦЭЦЭГ

ТАЙЛАН ГАРГАСАН:
МЭДЭЭЛЭЛ ТЕХНОЛОГИ, АРХИВ
БИЧИГ ХЭРЭГ ХАРИУЦСАН
МЭРГЭЖИЛТЭН

Ц.ДЭЛГЭРМАА